

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Монгол Улсын Их Хурлын чүүлганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар
зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгасан санал

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1.5 тэрбум” гэснийг “2.5 тэрбум” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, 26.2 дахь хэсэг, 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “05-ны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “05-ны” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан: Төсвийн байнгын хороо

---oOo---